



**ХЭНТИЙ АЙМАГ
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар А/70

Өмнөдэлгэр сум

**Газар эзэмших эрхийн гэрчилгээг өвлүүлж
эзэмшүүлэх тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дахь хэсэг, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 30.2 дахь хэсгүүдийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Цэдэнгийн Дамбачимэдийн газар эзэмших эрхийн гэрчилгээг өвлөж авах тухай нотлох баримтыг бүрдүүлэн өргөдөл гаргасан өв залгамжлагч иргэн Дэлэгийн Тунгалагмаа (CP66100507)-д өвөлжөө, хаваржааны зориулалттай газрыг 53 жилийн хугацаатай өвлүүлж эзэмшүүлсүгэй.

2.Газар эзэмших эрхийн гэрчилгээг өвлөн авсан иргэнтэй гэрээ байгуулан, биелэлтэд байнгын хяналт тавьж ажиллахыг газрын даамал (Ё.Мөнх-Өлзий)-д үүрэг болгосугай.

3.Газар эзэмших гэрээнд тусгагдсан зориулалт, нөхцөлийн дагуу газраа эзэмшин, гэрээний дагуу биелэлтийг жил бүр дүгнүүлж байхыг Дэлэгийн Тунгалагмаад даалгасугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2018 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн А/118 дугаар захирамжийн Цэдэнгийн Дамбачимэдэд холбогдох хэсгийг хүчингүйд тооцсугай.



Р.ЭНХТӨР



сумын Засаг даргын 2025 оны
08 дугаар сарын 05-ны өдрийн
А/Х дугаар захирамжийн хавсралт

№	Овог	Эцэг/эх/-ийн нэр	Нэр	Регистрийн дугаар	Байршил	Зориулалт	Газрын хэмжээ /га/
1	Чойжин	Дэлэг	Тунгалагмаа	CP66100507	5-р баг, Ар ганга 5-р баг, Өвөр ганга	Хаваржаа Өвөлжөө	1.0 1.0
Дүн							2.0

